



НОГООННУУР СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас:70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас:70423073
Цахим хаяг: Elbegeeuuree@yahoo.com

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.bayan-ulgii.gov.mn

2018 оны 3 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээ тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 14-нээс 3 дугаар сарын 23-ны хооронд хийхээр төлөвлөн аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 03-р сарын 02-ны өдрийн №30-р албан бичгээр 3 дугаар сарын 05-нд ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 16-наас 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 26-нд Ногооннуур сумын Засаг даргад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын багц хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд

мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Төр засгийн болон Сумын бодлогын хэрэгжилтийг шуурхай удирдлагаар хангах, үр дүнг шударгаар тооцох төрийн үйчилгээний бүтээмжийг нэмэгдлүүлэх, иргэддээ чанартай үйлчилгээ үзүүлэх, улмаар орон нутгийн хөгжлийг тэтгэх чадварлаг захиргааны байгууллагыг төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”, 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д заасны дагуу Ногооннуур сумын Засаг дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. 2017 оны төсвийг орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Ногооннуур сумын төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 10-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан тэмдэглэл тодруулга, бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Пластик”, “Аколоус” програм хангамж ашиглажээ.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Аймгийн ТТЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

6.1. Орлого, татаас санхүүжилтийн талаар:

6.1.1 Улсын төсвийн санхүүжилт

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 2275,5 сая төгрөгийн санхүүжилт, 1,8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

6.1.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагууд аймгийн төсвөөс 348,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 35,1 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 64,7 сая төгрөг хүлээн авчээ.

6.1.3 Үндсэн үйл ажиллагааны орлого

Ногооннуур сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагаанаас 1.4 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 1.4 сая төгрөгийн орлого оруулж, өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлсэн байна.

6.1.4 Орон нутгийн татварын орлого

Ногооннуур сумын ИТХ-аас сумын 2017 оны Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 35,0 сая төгрөгөөр баталжээ. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 38,6 хувийг ХАОАТатвараас, 46,3 хувийг бусад татвараас, 15,1 хувийг өмчийн татварын орлогоос оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Нийт орлогын дүн	35060.2	47757.3	12697.1	136.22%
Татварын орлого	9550.0	46619.3	11559.1	132.97%
ХАОАТатвар	13550.0	31422.6	17872.7	231.90%
Өмчийн татвар	5278.4	2993.0	-2285.4	56.70%
Бусад татвар	16231.8	12203.6	-4028.2	75.18%
Татварын бус орлого	0.0	1138.0	1138.0	
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО		0,00		

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 47,8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 12,7 сая төгрөгөөр буюу 36,2 хувиар давуулан биелүүлжээ. Нийт орлогын 65,8 хувийг ХАОАТатвар, 25,6 хувийг бусад татвараас, 6,3 хувийг өмчийн татвараас, 2,4 хувийг татварын бус орлогоос бүрдүүлжээ. Татварын бус орлогын төлөвлөгөө өгөгдөөгүй ба хүү торгууль, банкны хадгаламжийн хүүгийн орлогоос 1,1 сая төгрөгийн орлого оруулсан ба энэ нь орлогын 2,4 хувийг эзэлж байна

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 17.9 сая төгрөгөөр буюу 32.8 хувиар давж, бусад татвар 4,0 сая төгрөгөөр буюу 24,8 хувиар, өмчийн татвар 2,3 сая төгрөгөөр буюу 43,3 хувиар, үл хөдлөх хөрөнгө борлуулсны албан татвар 100 хувиар тус тус тасарчээ. Төлөвлөгөө өгөгдөөгүй татварын бус орлогоос 1,1 сая төгрөг оруулж орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелэгдэхэд гол нөлөө үзүүлжээ.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 3,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 47,8 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот

дансанд 16,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. Өмнөх оны 3,3 сая төгрөгийн давсан хэсэг зарцуулагдаагүй үлдэгдлээр гарсан байна.

Сумын төрийн сан дахь цалин хөлсний татварын орлогын 901 тоот дансаар нийтдээ 130,7 сая төгрөгийн орлогыг оруулж, аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Сумын төсөвт байгууллагуудаас төлсөн цалин хөлсний татварын орлогыг тухай бүр аймгийн ЦХТОрлогын дансанд төвлөрүүлж ажилласан байна.

6.1.5 Бусад орлого

Тайланд онд Орон нутгийн хөгжлийн санд 67,8 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 8,0 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн санд 19,8 сая төгрөгийн орлого оруулсан байна.

6.2. Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

6.2.1 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2017 оны урсгал зардалд нийтдээ 2727,8 сая төгрөгийн төсөв батлагдсаны 2275,5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 383,1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 67,8 сая төгрөгийг ОНХСангаас, 1,4 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр тусгажээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 2275,5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 383,1 сая төгрөгийн, ОНХСангаас 67,8 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үйл ажиллагааны орлогоос 1,4 сая төгрөгийг бүрдүүлж бүгд дүнгээр 2727,8 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсөвтөө багтаан зарлага гаргажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2727.8	2727.8	0,0%	0,00
1.1	Урсгал зардал	2727.8	2727.8	0,0%	0,00
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0,0%	0,0
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр	2727.8	2727.8	0,0%	0,0
2.1	Тусгай зориулалтын шилжүүлэгээс	2275.5	2275.5	0,0%	0,0
2.2	Орон нутгийн төсвөөс	383.1	383.1	0,0%	0,0
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	67.8	67.8	0,0%	0,0

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал:

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сумын ИТХурал	48.9	48.9	-	100.0
2	Сумын ЗДТГазар	359.4	359.4	-	100.0
3	Ахлах сургууль	1,290.9	1,290.9	-	100.0
5	Чихтэй БСургууль	164.9	164.9	-	100.0
6	Хөвд БСургууль	228.0	228.0	-	100.0
7	Улаанчулуут БСургууль	167.6	167.6	-	100.0
8	Хүүхдийн цэцэрлэг	375.1	375.1	-	100.0
9	Соёлын төв	50.4	50.4	-	100.0
10	ОНХСан	42.6	42.6	-	100.0
	Нийт дүн	2,727.8	2,727.8	-	100.0

Сумын төсөвт байгууллагууд батлагдсан төсвөө бүрэн авч, төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

/сая төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,727.80	2,727.80	-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,716.40	1,716.80	(0.40)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188.60	188.20	0.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91.40	91.40	-
2104	Хангамж, бараа материалын зардал	44.40	44.40	-
2105	Нормативт зардал	235.10	235.10	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8.40	8.40	-
2107	Томилолт, зочны зардал	6.60	6.60	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72.50	72.40	0.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19.10	19.10	-
213	Бусад урсгал шилжүүлэг	345.50	345.40	0.10

6.2.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 66,5 төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулсны дотор урсгал зардалд 66,5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үүнд:ЗДТГазарт аймгийн Засаг даргын давсан хэсгээс урсгалд зардалд 6,0 сая төгрөгийн, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 1,1 сая төгрөгийн, ХХААГазраас бруцеллёзын зардалд 52,8 сая төгрөгийн, Улаанчулуут бага сургуульд орон нутгаас 0,8 сая төгрөгийн, Соёлын төвд БСУШУЯамнаас 1,0 сая төгрөгийн, сумын орон нутгийн орлогоос

4,8 сая төгрөгийн нийтдээ 66,5 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан бүрэн зарцуулжээ.

6.2.3 Сангуудын зарцуулалт

Ногооннуур сумын ОНХСан нь оны эхэнд үлдэгдэлгүй ба тайлант онд 42,6 сая төгрөгийн санхүүжилт авч, 42,6 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд зарцуулж, оны эцэст үлдэгдэлгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 0,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 8,0 сая төгрөгийн орлогыг оруулж, тайлант онд зээл олгоогүй, оны эцэст 8,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. СХСан нь жилийн эцэст 257,4 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Эргэлтийн эмийн сангийн харилцах данс оны эхэнд 0,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 19,8 сая төгрөгийн орлого оруулж, 19,4 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 1,2 үлдэгдэлтэй гарсан байна.

6.3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаарх тайлбар, тодруулга

6.3.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4.20	25.40	21.20
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4.20	25.40	21.20
3121	Төгрөг	4.20	25.40	21.20
31211	Төрийн сангийн харилцах	3.40	24.20	20.80
31213	Арилжааны банк дахь харилцах	0.80	1.20	0.40

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 25,4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 1,2 сая төгрөг нь арилжааны банкин дахь, 24,2 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна. Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдлийн 16,0 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын, 8,1 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 1,2 сая төгрөг нь ЭЭСангийн, 0,001 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын дансны үлдэгдэл байна.

Арилжаны банкинд байгаа 0,5 сая төгрөг нь Эргэлийн эмийн сангийн дансны үлдэгдэл байна.

6.3.2 Авлагын бүртгэл, тайлагнал

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
33	АВЛАГА	275.3	265.40	9.89
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4.20	0.40	3.80

33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.09		0.09
33300	Татаас, санхүүжилтийн авлага	15.30		15.30
335	Бусад авлага	6.30	7.60	(1.30)
3351	Байгууллагаас авах авлага	6.30	7.60	(1.30)
336	Зээлийн авлага	249.40	257.40	(8.00)
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	249.40	257.40	(8.00)
33612	Хувь хүмүүст олгосон зээл	249.40	257.40	(8.00)

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 9,9 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Төсөвт байгууллагуудын авлага нь 6,3 са ятөгрөг нь ЗДТГазрын, 1,3 са ятөгрөг нь БДСургуулийн, 0,2 са ятөгрөг нь ХЦэцэрлэг, 0,2 са ятөгрөгийн СТөвийн бүгд 8,0 сая төгрөгийн авлагатай гарсан байна. Санхүүгийн албанаас сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын өмнөх оны үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, залруулга хийсэнтэй холбоотой үлдэгдэл оны 8,0 сая төгрөгөөр буурсан байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр гарын үсэг зуруулж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

6.3.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
35	БАРАА МАТЕРИАЛ	422.60	389.30	-33.30
351	Түүхий эд материал	5.40	5.40	-
354	Хангамжийн материал	357.90	335.20	-22.70
35600	Мал амьтад	59.30	48.70	-10.60

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 33,3 сая төгрөгөөр буурсан байна. Бараа материалын бүтцийг авч үзвэл 1,4 хувь нь түүхий эд материал, 86,1 хувь нь хангамжийн материал, 12,5 хувь мал амьтад байна. Тайлант онд нийтдээ 25,6 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 8,4 сая төгрөгийн материал акталсан байна.

6.3.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,842.40	6,409.30	3,566.90
391	Газар			-
392	Биет хөрөнгө	2,841.90	6,409.00	3,567.10
393	Биет бус хөрөнгө	0.50	0.30	(0.20)

Үндсэн хөрөнгө оны эхнээс 3566,9 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 7.2 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 3779,3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. Төсөвт байгууллагууд нийтдээ 3779,3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн

авснаас ЗДТГазар нь 3761,0 сая төгрөгийн, Бүрэн дунд сургууль 12,3 сая төгрөгийн, Чихтэй бага сургууль 1,5 сая төгрөгийн, Ховд БСургууль 2,0 са ятөгрөгийн, Улаанчулуут БСургууль 1,2 сая төгрөгийн, Соёлын төв 1,3 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авсан байна. Тайлант онд 51,6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан, акталж данснаас хассан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 199,2 сая төгрөгийн элэгдэл тооцож, данснаас хассан үндсэн хөрөнгийн 31,2 сая төгрөгний элэгдэлийг данснаас хасалт хийсэн байна.

6.3.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15.10	39.90	24.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15.10	39.90	24.80
413	Өглөг	15.10	39.90	24.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2.10	9.20	7.10
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4.40	0.80	(3.60)
4136	Бусад өглөг	8.60	29.90	21.30
41361	Байгууллагад төлөх өглөг	8.60	29.90	21.30

Оны эхэнд 15,1 сая төгрөгийн өглөгтэй байснаас, оны эцэст 39,9 сая төгрөг гарч, өглөг 24,8 сая төгрөгөөр өссөн байна. Оны эцсийн өглөг нь сумын төсөвт байгууллагуудад сумын ЗДТГазар 1,0 сая төгрөгийн, ИТХурал 2,2 сая төгрөгийн, БДСургууль 4,7 сая төгрөгийн, Чихтэй БС 0,2 сая төгрөгийн, Ховд бага сургууль 0,4 са ятөгрөгийн, Улаанчулуут БС 0,3 сая төгрөгийн, ХЦэцэрлэг 1,0 сая төгрөгийн, СТөв 0,2 сая төгрөгийн, ОНХСан 29,9 сая төгрөгийн бүгд 39,9 сая төгрөгийн тус тус өглөгтэй гарчээ. Төсөвт байгууллагуудын ихэнх өглөг ЗГаазраас олгосн Сахилга үр дүнгийн урамшуулал цалингийн байгууллагаас төлөх 11 хувийн НДШимтгэлийн өглөг, ОНХСангийн 29,9 сая төгрөгийн өглөг тус тус эзэлж байна.

6.3.6 Цэвэр хөрөнгө/өмчийн талаар

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн нийт дүн 7049,4 сая төгрөг буюу ЗГОКапитал 1558,4 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1651,8 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 3839,2 сая төгрөг байна. Тайлант онд 3503,9 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн 3839,2 сая төгрөг болж өссөн байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Ногооннуур сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу shilendans.gov.mn вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулсан байна.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2017 оны 1-9 дүгээр сарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар хуулийн 6-р зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.3.5, 6.3.8, 6.3.9 дэх заалтуудыг зөрчсөн зөрчил илэрч албан шаардлага өгөгдөж, биелэлтийг 2017.12.26-ны өдрийн №122 тоотгоор ирүүлсэн байна.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-Nogoonnuur sumiin TTZ файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

Найм. Аудитын дүнгийн талаар

8.1. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 30 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

8.2. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний Орон нутгийн орлогын бүртгэл, тайлагнал, санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэл, төсөвт байгууллага, сангуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг нэгтгэх, тулган баталгаажуулах зэргээр ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

8.3. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитаар санхүүгийн тайланд нөлөөлэх материаллаг алдаа зөрчил гараагүй. Санхүүгийн тайлангийн аудитаар дараахь алдаа зөрчил илэрлээ.Үүнд:

"Эйшиа Миллионс" ХХК-наас 2.4 сая төгрөгийн, "Фишекс" ХХК-наас 2.4 сая төгрөгийн бүгд 4.8 сая төгрөгийн барагшуны орлогыг 2017 оны 7-р сарын 03-нд сумын Байгаль орчин нөхөн сэргээх тусгай сангийн барьцаа 100020855301 тоот дансанд оруулж, ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансанд 7 дугаар сарын 20-нд шилжүүлэн авч орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансаар дамжуулахгүй шууд зарцуулж, сумын төсвийн гүйцэтгэлд оруулаагүй, нэмэлт санхүүжилтээр тайлагнасан байна.

Тодруулбал: Сумын Засаг дарга нь агнуурын гэрээний нөөц тогтоох 2.1 сая төгрөгийн, хандивт шилжүүлсэн 1.5 сая төгрөгийн бүгд 3.6 сая төгрөгийн шилжүүлгийн төлбөрийн хүсэлтэнд эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж 1 дүгээр гарын үсэг зурж, төрийн сангаар гүйлгээ хийлгүүлсэн. Төсөвт байгууллагуудаас хандивын 1.5 сая төгрөгийг энэхүү дансанд буцаан оруулж, Засаг даргын орлогчийн захирамжаар 1.0 сая төгрөгийг багийн өдөрлөгт, 1.7 сая төгрөгийг ЗДТГазрын дарга, нягтлан бодогч нар 1, 2 дугаар гарын үсэг зурж тээвэр шатахууны зардалд зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.2.2, 6.2.5, 6.3.4, 6.4.1, 6.6.2, 6.6.4, 16.5.5, 41.2.2, 41.2.3, 42.7 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын Засаг даргад зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2. Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байсан хавсралтанд заасан нэр бүхий ажилчдад Засгийн газраас олгосон 300000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулалыг олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бус олгосон урамшуулал 0,5 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

3. ЗДТГазарт 2017 оны 12-р сарын сарын 01-нээс тооцооны 1 нягтлан бодогчийн орон тоог батлагдсан орон тооноос илүү авч ажиллуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дах заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын Засаг даргад зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

4. Сум хөгжүүлэх сан нь жилийн эцсийн байдлаар 257,4 сая төгрөгийн зээлийн авлагатай бөгөөд санхүүгийн тайланд зээлийн хүүгийн авлагыг тусад нь харуулаагүй, авлагын үлдэгдэлд тайлант хугацааны хүүг тооцож, орлогоор бүртгэж аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд тэмдэглэж цаашид анхаарч ажиллахыг зөвлөв.

5. Шүүхийн шийдвэрээр сумын ЗДТГ-ын 1 ажилтанд ажилгүй байсан хугацааны цалинд 7,2 сая төгрөгийг сумын тамгын газрын цалингийн сангаас олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд тэмдэглэв.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2-т зааснаар ямар нэг арга хэмжээ авагдаагүй, буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаас хохирлыг төлүүлж аваагүй байна.

6. Шүүхийн шийдвэрээр 2014 онд авсан хогийн машины үнэ 24.1 сая төгрөгийг тайлант оны ОНХСангаас олгосон байна. Үүнээс шалтгаалж ОНХСан оны эцэст 29.9 сая төгрөгийн өглөгтэй гарахад нөлөөлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд тэмдэглэв.

8.4. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй болно.

8.5. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

8.6. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн орлогын зарцуулалтай холбоотой зарим асуудлыг гүйцээж шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар үзэх шаардлагатай.

8.7. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягаар нэгтгэж харуулав.

8.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

8.9. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Ногооннуур сумын Сумын ИТХурал, Соёлын төвийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж, Бүрэн дунд сургууль, Чихтэй, Ховд, Улаанчулуут бага сургуулиуд, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд бие даасан дүгнэлт гаргалаа.

Сумын Засаг даргын тамгын газар, Улаанхад бага сургууль, ОНХСан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд оруулав.

Аудитын үр дүнг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /мян. төг/	Аудиторын санал дүгнэлт бүгд	Үүнээс			
			Зөрчилгүй санал дүгнэлт	Хязгаарлалттай санал дүгнэлт	Сөрөг санал дүгнэлт	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Сумын ИТХурал	-	-	-			
Сумын ЗДТГазар	486,0	-	-			
Бүрэн дунд сургууль	6775,0	1	1			
Чихтэй бага сургууль	-	1	1			
Ховд бага сургууль	-	1	1			
Улаанчулуут бага сургууль	-	1	1			
Хүүхдийн цэцэрлэг	-	1	1			
Соёлын төв	-	-	-			
ТТЗ-ийн СНТайлан	10135.3	1		1		
Дүн	17396.3	6	5	1		

8.10. Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН
Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК
Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА
Огноо:2018.03.23